



ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ



E-NEWSLETTER

f facebook.com/Rtcc.m0n
globe http://rtcc.mrtd.gov.mn
envelope info@rtcc.mrtd.gov.mn
phone +976 77244409

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН
2020 оны 01 дүгээр сарын дугаар



2020 оныг “ЧАДВАРЛАГ АЖИЛТАН-АЮУЛГҮЙ АЖЛЫН БАЙР”-ыг дэмжих жил болгон зарлалаа.

Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар 2020 оныг Зам, тээврийн салбарын хэмжээнд “Сахилга хариуцлага-Хөдөлмөрийн аюулгүй байдлын жил” болгон зарласантай холбоотой “ГТХЗНТ” УТУГ нь “ЧАДВАРЛАГ АЖИЛТАН-АЮУЛГҮЙ АЖЛЫН БАЙР”-ыг дэмжих жил болгон зарлалаа.

“Чадварлаг ажилтан-аюулгүй ажлын байр” жилийн хүрээнд ажлын байрны соёл 5Ц хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төвийн мэргэжилтнүүдийн хэлний түвшинг нэмэгдүүлэх, дотоод гадаадын сургалтад хамруулах, идэвхжүүлэх болон спортын арга хэмжээг тогтмол зохион байгуулах, эрүүл мэндийн үзлэг оношилгоонд хамруулах, мөн холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн, аюулгүй ажлын байр, орчин, нөхцөлийг бүрдүүлж ажиллана.



2020 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөлөө.



“Инженер-Ирээдүй” төслийн хүрээнд эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн чиглэлээр хүний нөөцийг бэлтгэх, сургах ажлыг хэрэгжүүлэх, хүний нөөцийн нэгдсэн мэдээллийн сантай болж түүний үйл ажиллагааг цахимжуулж тогтмол ажиллуулах.

ОХУ-ын Зам харилцааны улсын их сургуульд салбарын 15 инженерийг “мэдээлэл технологи”-ийн чиглэлээр магистрийн 2.5 жилийн эчнээ хөтөлбөрт сургах.



БНХАУ-ын Харбины төмөр замын судалгааны институттэй хамтран “Галт тэрэг найруулах төлөвлөгөөг цахим хэлбэрт шилжүүлэх, сэлгээний ажлын хяналтын автоматжуулсан систем”-ийн судалгаа боловсруулах.

Япон Улсын “Жет Коннект” ХХК-тай хамтран “Галт тэрэгний зурмаг төлөвлөлт, хяналтыг автоматжуулах систем”-ийг хөгжүүлэх судалгаа хийх.



БНСУ-ын “Койка” олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран “ГТХЗНТ” УТУГ-ыг бэхжүүлэх, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлын бодит цагийн хянах технологи нэвтэрүүлэх” төсөл боловсруулах.

Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтны сургалтын модуль /сургалтын танхим, бааз/ байгуулах судалгааны ажил боловсруулах

ГТХЗНТ-ийн дэргэдэх шинжлэх ухаан, технологийн зөвлөлийг шинэчлэх, ШУТИС-ийн электроникийн салбартай хамтран ажиллах.

Мэдээ, мэдээлэл



"Төмөр замаар аюултай ачаа тээвэрлэх, ачиж буулгах, хадгалах журам"-ыг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдлаа.

Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 10 дугаар тушаалаар Монгол Улсын Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн "Төмөр замаар аюултай ачаа тээвэрлэх, ачиж буулгах, хадгалах журам"-ыг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

Ажлын хэсгийн хүрээнд Төмөр замаар аюултай ачаа тээвэрлэх, ачиж буулгах, хадгалах журмын шинэчлэн боловсруулж, найруулгын төсөлд салбарын нийт албан хаагчдаас санал аван нэгтгэн боловсруулахаар ажиллаж байна.



Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд саналаа тусгалаа.

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах саналыг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 348 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгийн нарийн бичгийн дарга бөгөөд ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-ын ахлах мэргэжилтэнд хүргэж танилцуулав.



Монгол-Солонгосын төмөр замын хамтын ажиллагааны өдөрлөгт оролцлоо.

2020 оны 01 дүгээр сарын 14-нд Худалдаа аж үйлдвэрийн танхимд зохион байгуулсан Монгол-Солонгосын төмөр замын хамтын ажиллагааны өдөрлөгт Төвийн удирдлагууд болон мэргэжилтнүүд оролцлоо.



Мэдээ, мэдээлэл



"Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээний нэгдсэн санг бүрдүүлэн ажиллаж байна.



Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмыг хэрэгжүүлж төмөр замын салбарын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хөтлөх, боловсруулах, ашиглах үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна.

Үндэсний статистикийн хорооны даргын тушаалаар батлагдсан улсын тайлан Т-9 маягтын дагуу 2019 оны 12 дугаар сарын төмөр замын тээврийн тээвэрлэлтийн мэдээг Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого хэрэгжүүлэх газар, Бодлого төлөвлөлтийн газарт хүргэж танилцуулсан.

2019 оны 12 дугаар сарын статистик мэдээ, мэдээллийг нэгтгэж нийгэм, эдийн засгийн байдалд нөлөөлсөн байдлаар буюу төмөр замын ачаа болон зорчигч тээвэрлэлт, ачаа ачилт, зорчигч болон ачаа эргэлт, дамжин өнгөрсөн болон тээвэрлэсэн ачаа, галт тэрэгний зурмагийн биелэлтэд дүн шинжилгээ хийж, ЗТХЯ-ны www.mrtcc.gov.mn цахим хуудаст инфографик хэлбэрээр байршуулж олон нийтэд нээлттэй, ил тод мэдээллээ.



"МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ" чиглэлээр сургах магистрын эчнээ хөтөлбөрт бүртгэж эхэллээ.



"Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв" УТУГ нь "Инженер-Ирээдүй" хөтөлбөрийн хүрээнд мэдээллийн технологийн инженер бэлтгэх зорилгоор ОХУ-ын Эрхүүгийн зам харилцааны улсын их сургуультай хамтран ажиллах санамж бичиг байгуулан ажиллаж байна.

Уг хөтөлбөр нь 2020-2023 онд жил бүр салбарын 15 инженерийг "мэдээллийн систем ба технологи" чиглэлээр магистрын 2,5 жилийн эчнээ сургалтыг зохион байгуулна.

Аж үйлдвэрийн IV-р хувьсгал, дижитал эринтэй хөл нийлүүлэн өөрсдийн мэдлэг боловсролоод ээшлүүлэх сонирхолтой салбарын мэргэжилтэн, инженерүүдийг бүртгэж байна.





ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ

ЭРХҮҮГИЙН ЗАМХАРИЛЦААНЫ
УЛСЫН ИХ СУРГУУЛЬД
"МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ"
ЧИГЛЭЛЭЭР СУРГАХ МАГИСТРЫН
ЭЧНЭЭ ХӨТӨЛБӨР


2019 оны 12 дугаар сард өссөн дүнгээр зорчигч тээвэрлэлт 2948 мян.зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 14.6%-аар өссөн, ачаа тээвэрлэлт нь 28143 мян.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 9.2%-аар өссөн үзүүлэлттэй байна.



ИНФОГРАФИК




Төмөр замын тээврийн үндсэн үзүүлэлт



Зорчигч тээвэрлэлт 2019 оны арванхоёрдугаар сард 222 мян.зорчигч тээвэрлэсэн, ачаа тээвэрлэлт нь энэ сарын байдлаар 2523.4 мян.тн ачаа тээвэрлэсэн байна.

Дамжин өнгөрсөн ачаа /мян.тн/



Дамжин өнгөрсөн ачаа 2019 оны арванхоёрдугаар сард 274.6 мян.тн ачсан байна.

Ачилт- ачааны төрлөөр /2019 оны 12 дугаар сард/




Ачилтаар 2019 оны арваннэгдүгээр сард нүүрс, төмрийн хүдэр, зэс, молибдений баяжмал, нефтийн бүтээгдэхүүн, барилгын материал өссөн үзүүлэлттэй байна. Нийт 1948.3 мян.тн ачсан байна.



Корона вирусын халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж байна.

Шинэ төрлийн Корона вирусын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор төвийн хэмжээнд халваргүйжүүлэлт, ариутгал хийж байна. Нийт ажилтнуудад гар ариутгалын бодис, нэг удаагийн маскийг тарааж, өрөөний ариутгалыг 2 цаг тутамд хийж байна. “МАСК ДАВАЛГАА- АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ БИД БИЙ БОЛГОНО” уриалгыг гаргаж, нийт ажилтнуудад вирусын халдвараас урьдчилан сэргийлэх зурагт хуудас, мэдээ мэдээллийг танилцуулан ажиллаж байна.



“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль” сэдвээр сургалт зохион байгууллаа.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв, “Нийслэл адвокатс” ХХН-тэй хамтран “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль” сэдвээр сургалт, мэдээллийн арга хэмжээ зохион байгуулж нийт ажилтныг хамруулав.





“БТЕГ” ХХК болон “УБТЗ” ХНН-ийн төлөөлөгчтэй уулзалт зохион байгууллаа.

Төв нь “БТЕГ” ХХК болон “УБТЗ” ХНН-ийн удирдлага болон мэргэжилтнүүдийг хүлээн авч ирээдүйд хэрэгжүүлэхээр зорьж буй төсөл хөтөлбөр, төвийн зорилго, зорилтыг танилцуулж, төсөлтэй холбогдуулан ОХУ-ын Эрхүү хотын зам харилцааны их сургуульд мэдээлэл технологийн чиглэлээр магистрын эчнээ хөтөлбөрт инженерүүдийг хамруулах, хамтран ажиллахыг уриаллаа.





ХБНГУ

Нюрнбург-Ингольштад-Мюнхэн чиглэлд 2 давхар зорчигч тээврийн галт тэрэг ашиглалтанд орлоо

DB Regio-ийн захиалсан шинэ хөдлөх бүрэлдэхүүнийг Skoda Transportation компани үйлдвэрлэжээ. 2018 оны сүүлчээр Герман улсын EISENBANH-CERT (EBC) гэрчилгээжүүлэлтийн байгууллага нь TSI компанийн 109 E3 цуврал зүтгүүр, хоёр давхар вагонд Европын холбооны төмөр замын технологийн нийцтэй байдлыг хангаж, техник, ашиглалтын журамд нийцэж буйг нотолсон гэрчилгээ олгосон. Хот хоорондын хурдны галт тэрэгний дээд хурд нь 250 км/цаг боловч 190 км/ц хурдтай ажиллана. Галт тэрэгний бүрэлдэхүүнд Эмил Затопек 109 E3 серийн зүтгүүр, зорчигчийн вагон, хяналтын кабин бүхий вагон багтана. Энэ галт тэрэг нь тэргэнцэртэй зорчигчид болон түүний дагалдан яваа хүмүүст зориулсан суудал, 40 гаруй унадаг дугуйны багтаамжтай тасалгаа, хүүхдийн тасалгаа, 2-р зэрэглэлийн 676 тасалгаатай. Мюнхен ба Нюрнберг хотын хооронд шинэ экспресс галт тэргээр 1 цаг 45 минутын хугацаанд аялна.





Нидерланд улс

Фрисланд, Гронинген мужууд байгаль орчинд ээлтэй тээвэрлэлтэд шилжихээр төлөвлөж байна.

Техник, эдийн засгийн судалгаа хийсэн Рикардо, Аркадис компаниуд хамтран 2025 он гэхэд дизель зүтгүүрээс бүрэн татгалзаж, бүс нутгийн төмөр замын чиглэлүүдэд байгальд ээлтэй галт тэрэг ашиглалтад оруулахаар төлөвлөж байна.

Судалгааны явцад төмөр замын галт тэрэгний хөдлөх бүрэлдэхүүнд цэнэглэгддэг зай хураагуурын төхөөрөмжийн технологийг хөгжүүлэх хэтийн төлөвт дүн шинжилгээ хийж, устөрөгчийн түлш ашигладаг галт тэрэгний туршлагыг судалж, цахилгаан дамжуулах шугамын хэтийн төлөвийг үнэлсэн.

Үүний үр дүнд төмөр замын зорчигч тээврийг байгаль орчны шинэ түвшинд шилжүүлэх эрчим хүчний хоёр хувилбарыг санал болгов. Нэгдэх хувилбар нь төмөр замын хэсгүүдийг хэсэгчлэн цахилгаанжуулах боломжийг олгодог бөгөөд галт тэрэгний зай хураагуур нь хөдөлгөөний үед болон зогсож байх үед ч эрчим хүчээ цэнэглэх боломжтой. Хоёрдахь хувилбар нь устөрөгчийн түлшний цахилгаан энергийг зай хураагуур болон татах цахилгаан хөдөлгүүрийн тэжээлд хувирна.





Итали улс

Италийн төрийн төмөр зам Ломбарди мужийн төмөр замын сүлжээний дэд бүтцийг шинэчлэхээр төлөвлөж байна

ДТХ-ийн системийг сайжруулахад онцгой анхаарал хандуулан ажиллаж байна. 2019 онд Бергамо-Ровато чиглэлийн шугам дээр АСС-М микропроцессорын төвлөрүүлэлтийн шинэ системийг суурилуулж ашиглалтанд оруулсан ба 2020 онд Вогара-Пиакенза, Каранте-Понте-сан-Пьетро, Романо-Брешиа шугамуудад суурилуулахаар төлөвлөж байна.

Домодоссоло болон Тортона өртөөн дээр МПЦ АСС-микропроцессорын төвлөрүүлэлтийг суурилуулна. МПЦ АСС-микропроцессорын төвлөрүүлэлтийн систем нь галт тэрэгний хөдөлгөөнийг зохицуулах сум болон дохиог хянах функцуудыг нэгтгэснээрээ давуу талтай. АСС-М нь галт тэрэгний цагийн хуваарийг шуурхай зохицуулах, зорчигчдод зарлан мэдээлэх систем, диспетчерийн төвлөрүүлэлттэй хамтран ажилладаг. Сум, дохио, гарам болон хяналтын бусад объектод байрласан орон нутгийн хяналтын байгууламжуудтай тоон мэдээлэл солилцдог.

Одоо хэрэгжиж байгаа хөтөлбөрийн хүрээнд 2021 онд Кьяссо-Монца болон Карнате-Монца, 2022 онд Милана Ламбрате ба Порта-Гарибальди чиглэлийн шугамын дохиоллын системийг шинэчлэх ажил хийгдэнэ. 2022 онд Милан хотод галт тэрэгний хөдөлгөөнийг удирдах Европын галт тэрэгний хяналтын систем ETCS-ыг нэвтрүүлэхээр төлөвлөж байна.





Турк улс

2019 оны 3-р сард Мармарай шугамын замын хөдөлгөөнийг нээсэн.

Босфорын хоолойн доогуур туннелээр дамжин Ази, Европыг холбосон энэ шугамын барилгын эхний үе шат 2013 онд ашиглалтад орсон бөгөөд 2019 онд бүрэн ашиглалтад орсон. 43 өртөө бүхий 76 км урттай хурдны зам нь Босфорын 14 км урттай туннел болон Стамбул хотыг дайран өнгөрч, Азийн Гебзе, Европын Халкали хотыг холбодог. Уг шугам нь Европын галт тэрэгний хяналтын систем ETCS 1-р түвшин ба CBTC радио сувгийн галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын систем, түүнчлэн радио холбооны GSM-R сүлжээгээр тоноглогдсон. Энэ хоёр системийг Siemens компани нийлүүлсэн.



Австри улс

Австри улсад хамгийн том ачаа боловсруулах цогцолбор бий болно

Өнөөгийн байдлаар RCG нь Рижека боомт болон Австрийн төмөр замын өртөөд хооронд жилд 1 сая тонн ачаа тээвэрлэлтийг зохион байгуулдаг. Ачаа тээвэрлэлтийн ихээхэн хэсгийг нь төмрийн хүдэр, чулуун нүүрс эзэлдэг. Luka Rijeka оператор болон Австрийн төмөр замын холбооны охин компани болох RCG-ийн хооронд байгуулсан гэрээнд боомтын хөгжлийг харгалзан маршрутын дагуу тээвэрлэлтийг нэмэгдүүлэхээр тусгасан. Ойрын үед Рижека боомт нь Төв Европын хамгийн том ачаа боловсруулах цогцолбор болно. Rijeka Gateway төслийн хүрээнд боомтыг хөгжүүлэхэд ихээхэн хэмжээний хөрөнгийг Дэлхийн банкнаас санхүүжүүлэх болсон.



“МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ” чиглэлээр сургах магистрын эчнээ хөтөлбөр

О.У.Т.СЭРГИЙН МЭДЭЭЛЭЭНИЙ ХӨТӨЛБӨР ҮНДЭМ ХАМГААГАГЧИЙН ӨНӨН

ЭРХҮҮГИЙН ЗАМХАРИЦЛААНЫ ҮЛСБЭН ИХ СУРГУУЛЬД “МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ” ЧИГЛЭЛЭЭР СУРГАХ МАГИСТРЫН ЭЧНЭЭ ХӨТӨЛБӨР

ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

- Урвалд төгсөж, өөний төлөмрөжөөр, жижигхэн бизнесийг нэвтрэгдэгдэг.
- Салбарын боловсон зүүнчид өөний урвалд сургалтад төрийн болгоо хийгдэх ёстой.
- Аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгалд хөгжих үе шийжээ орж байна.



АЖ ҮЙДЭВРИЙН IV ХУВЬСГАЛ ТӨМӨР ЗАМЫН САЛБАРТ

2022-23
Төмөр замын үйлчилгээний, технологийн үйлчилгээний үйлчилгээний төлөвөгдөгдөг.

2024
Big data (Big data)
Мэдээллийн технологийн үйлчилгээний төлөвөгдөгдөг.

2025
Цахим инноваци
Цахим инновацийн үйлчилгээний төлөвөгдөгдөг.

2025
ОХУ-ын төмөр замын стратеги
Дамуулан хөгжих үйлчилгээний төлөвөгдөгдөг.

2019
2020

Сentoo

ИНЖЕНЕР ИРЭЭДҮЙ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

ОХУ-ын Эрхүүгийн зам харилцааны үйлчилгээний сургуулиаар хамтран ажлаагаа сайнжирч өгсөн байгуулал, хоорондоо уяагаа хийсэн.

“ТЭГЭХИ” УТҮГ 2019.11.14

Эрхүүгийн зам харилцааны үйлчилгээний сургуулийн төлөвөгдөгдөг:
- ЭХҮИС-ийн Ер-орлогч дарга Оршанов А.Н.
- Дамуулан хөгжих үйлчилгээний төлөвөгдөгдөг Магистров Ю.И.
- Дамуулан хөгжих үйлчилгээний төлөвөгдөгдөг Митинская В.М.
- УБ Хөг-дэх салбар сургуулийн эзлэгч В.Чингалуун

ЭРХҮҮ ХИТ 2019.06.25



Сургалт



“МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ” чиглэлээр сургах магистрын эчнээ хөтөлбөр.

ЭРХҮҮ ХОТВИЙ ЗАМ ХАРИЛЦААНЫ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

<p>Эрхүүгийн зам харилцааны улсын сургууль нь анх 1932 онд байгуулагдсан.</p>	<p>7 факультет, соёл боловсролын нөлөөт мэргэжилтэй сургалт, олон улсын харилцааны сургалттай.</p>
<p>21 тунгаван, 6-н корпус 100 гаруй мэргэжилтэй лабораторийн тусламь дагал профессор ажилладаг.</p>	<p>ОХУ-ийн их дэд сургууль дахь интернацлал бай болон хамгаалаары эдүурт ордаг.</p>
<p>Өөнтөгөр 12000 оюутан өлөр болон оройн цашар сурагша байна.</p>	<p>Шинэчлэл уриан, технологийн өнөөдөр, дүүж өмнөний претягала, соёл ажиллагаа уриан эдүуртүүлэ, байгаа мөлон байуулагддаг.</p>

ТӨВИЙН АЛСЫН ХАРАА

Хамтын ажиллагаа

Зам тээврийн хотгийн яам

KOICA

Дата товч (Big data)

Дата товч ажиллагаа 45-50 мянгангай технологийн өмнөний өмнөнийг.



МАГИСТРЫН ЭЧНЭЭ СУРГАХ ХӨТӨЛБӨР

ОХУ-ын "ЭХХИС" магистрын эчнээ хөтөлбөрт 2.5 жилээр мэдээллийн технологийн чиглэлээр салбарын жилд 15-20 магистр технологийн ажиллагааг сургалар төлөрөгдө.

2020-2021: 2-3 жил, IT магистр

2021-2022: 2-3 жил, IT магистр

2022-2024: 2-3 жил, IT магистр

45000 IT өмнөний

ТАВИГДАХ ШААРДИАГА

Төмөр замын өмнөний болон эрэгтэй байх

Мэргэжил өөрч 3 ба түүнтэй дөрвө жил ажиллагсан байх

Орос, англи хэлний суурь мэдлэгтэй байх

Цаашдаг төмөр замын салбар төлөрөгч сууринд ажиллах

Бүрдүүлэх материал:

1. Иргэний үгэмэлх /сууль/
2. Бакалаврын диплом /сууль/, орос хэлд хорьүүлх
3. Гадаад өмнөний /сууль/-орос хэлд хорьүүлх
4. Цэжэ сураг 2% /сүүний 6 сард өмнөний/



THANK YOU!


77244403, 77244400

info@rtcc.mfird.gov.mn

http://rtcc.mfird.gov.mn

2th floor, gazar business center
zanchin street, 1st khoroо
Bayangol distric,
Ulaanbaatar, mongolia



 **8-р давхар, Хан-Уул цамхаг,
Б.Шаравын гудамж 6,
3-р хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот 17042, Монгол Улс**

